



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Бүртгэлийн маягт батлах тухай

Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг Монгол улсын Монгол улсын Засгийн газрын 2020 оны 222, 2021 оны 378 дугаар тогтоол, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын 2022 оны А/16 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эмийн хяналтын лабораторийг тус газарт нэгтгэсэнтэй холбогдуулан Эм шинжлэх лабораторид ашиглах анхан шатны бүртгэлийн маягтыг шинэчлэн боловсруулж, хавсралтаар баталсугай.

2.Анхан шатны бүртгэлийн маягтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Эм шинжлэх лаборатори (Ш.Энхзаяа)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Намхайноров)-т тус тус даалгасугай.

ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Д.УРАНЗАЯА



142022 01028